



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРАВДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 07

Чингис хот

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг
Хэнтий аймагт хэрэгжүүлэх “Гучин сая мод”
хөтөлбөр, төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Аравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймгийн хэмжээнд 2022-2030 он хүртэл хэрэгжүүлэх “Гучин сая мод” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Гучин сая мод” хөтөлбөрийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрдүүлж, төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэн үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Ж.Ганбаатарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХЭРЛЭНЧУЛУУН

**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭНТИЙ АЙМАГТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ “ГУЧИН САЯ МОД” ХӨТӨЛБӨР
(2022-2030 он)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү хөтөлбөр нь хүн төрөлхтний өмнө тулгарч буй дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх, ой мод, усны нөөцийг хамгаалах экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэхэд чиглэнэ.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

2.1 Хөтөлбөрийн зорилго

Монгол орны ойн салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, Хэнтий аймгийн байгалийн бүс бүслүүр, хөрс, цаг агаарын онцлогт тохирсон мод буцыг тарьж ургуулах, арчлан хамгаалах, ойн аж ахуйн төвүүдийг бүсчлэн байгуулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулахад хувь нэмэр оруулж аймгийн хэмжээнд “Гучин сая мод” тарьж ургуулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

- 2.2.1. Мод тарих арга хэмжээний газар зохион байгуулалтын төлөвлөлт, ажлын зураглалыг гаргах
- 2.2.2. Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх
- 2.2.3. Ойт хээрийн болон хээрийн бүсийн доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, ойн зурвас байгуулах, мод үржүүлэг, тарьц суулгацыг нэмэгдүүлэх
- 2.2.4. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт тэй уялдуулан цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро-ойн аж ахуйг хөгжүүлэх
- 2.2.5. Иргэдийн дунд бүх нийтийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх, мод тарих сургалт сурталчилгааны ажлыг бүх түвшинд зохион байгуулах
- 2.2.6. Мэргэжилтэй ажилтан, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх

2.3 Хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2022-2030 оны хооронд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат - 2022-2024 он

Хоёрдугаар үе шат - 2025-2030 он

2.4 Хөтөлбөрийн санхүүжилт

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тухайн төсвийн жилд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хувийн санхүүжилтийг ой мод, ойн санг нэмэгдүүлэх, хамгаалах мод тарих усжуулалт, бордоо, хөрс

хамгаалалт, байгальд ээлтэй стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулан төлөвлөж, түүнийг хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Олон улсын зээл, тусламж
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
- Орон нутгийн тусгай сангууд
- Орон нутгийн хөгжлийн сан
- Хувийн хөрөнгө оруулалт
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр



ГУРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохион байгуулалт, ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн үр дүнг тооцох, тайлагнах ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны дугаар сарын-ны өдрийн аравдугаар хуралдааны дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар байгуулагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг хариуцна.

3.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сумдын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Политехникийн коллеж, Насан туршийн боловсролын төв, Сум дундын болон сумын ойн ангиуд, бусад холбогдох байгууллагууд хангаж ажиллана.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1. Мод тарих арга хэмжээний газар зохион байгуулалтын төлөвлөлт, ажлын зураглалыг гаргах – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

- Сум, тосгодын төвийн ногоон байгууламжийн байрлалын зураглал гаргаж мэдээллийн сан бий болгож сумдад хүлээлгэж өгөх
- Шинээр мод таригдах газрыг ойжуулалт, ногоон байгууламж тус бүрээр гаргаж сум бүрт зураглал хийж, сумдад хүлээлгэж өгөх
- Газрын доройтол, цөлжилтөд өртсөн газрын судалгаа гаргаж, нөхөн сэргээх мод тарих ажилд ашиглах
- Шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсөлд ногоон байгууламжийн тохижилтийн хэсгийг тусгах, гүйцэтгэлд хяналт тавьж хүлээж авах
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын саналыг авч тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод үржүүлгийн газрыг төлөвлөж оруулах, хууль тогтоомжинд нийцүүлэн олгох асуудлыг судлах, шийдвэрлэх
- Холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран судалгаа хийж Чингис хот, Бор-Өндөр сум болон бусад сумдын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа саарал усыг ногоон байгууламжийн усжуулалтанд ашиглах

4.2. Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх – Сумын Засаг дарга

- Бүх нийтээр мод тарих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх
- Гэр бүлийн хүрээнд мод тарих ажлыг бүх нийтийг хамруулан зохион байгуулж “Өрх бүр ногоон төгөл” аяныг хэрэгжүүлэх
- Нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж ургуулсан иргэдийг урамшуулах ажлыг зохион байгуулах
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд мод тарих газар, мод үржүүлгийн газрыг төлөвлөж тусгах
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд мод тарих, арчлах, хамгаалах ажлыг зохион байгуулах
- Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг мод тарих үйл ажиллагаанд дайчлан оролцуулах
- Сум, тосгоны төвийн ногоон байгууламжийг арчилж ургуулах, хамгаалах ажлыг байнгын эзэнжүүлж хариуцлагажуулах
- Орон нутгийн өмчид бүртгэлтэй усны машин, ус хадгалах сав (ёонкс) зэргийг сумын болон сум дундын ойн ангиуд, мод үржүүлгийн газруудад хуваарилах ажлыг зохион байгуулах

4.3. Ойт хээрийн болон хээрийн бүсийн доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, ойн зурвас байгуулах, мод үржүүлэг, тарьц суулгацыг нэмэгдүүлэх – Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумын болон сум дундын ойн ангиуд

- Аймгийн хэмжээний мод, модлог ургамлын суурь судалгааг бүс нутаг тус бүрээр гаргах, ойн доройтолд орсон болон хортон шавьжид өртсөн талбай, нөхөн сэргээх шаардлагатай газрын суурь судалгааг гаргах (Хэрлэн голын татмын бургасан ойг хамруулна)
- Ойт хээрийн бүсийн сумдад ойжуулах ажлыг зохион байгуулах
- Хээрийн бүсийн сумдад автозамын болон элсний нүүдлээс хамгаалах хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах
- Хэрлэн голын татмын бургасан ойн доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, бургасжуулах
- Ойн мэргэжлийн байгууллагуудын өөрийн хөрөнгөөр хийгдэх ойжуулалтын арга хэмжээний гүйцэтгэл, чанарыг сайжруулна.
- Иргэд, нөхөрлөл, ой мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийж, улсын ойн санд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах
- Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Цэнхэрмандал сумын болон сум дундын ойн ангиудыг түшиглэн мод үржүүлгийн газруудыг өргөтгөж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэн ойжуулалтын ажилд шаардлагатай тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх
- Дадал, Хэрлэн, Баян-Овоо суманд шинээр мод үржүүлгийн газар байгуулан навчит модны суулгацын нөөц бүрдүүлж, ногоон байгууламжийн тарилтанд гаргах
- Үрийн нөөц бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх
- Ой бүхий Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин сумдын байгалийн ойгоос мод шилжүүлэн суулгахгүй байхад хяналт тавих

- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтныг орон тоогоор ажиллуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- Мод тарих, арчлах, ургуулах чиглэлээр сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулах
- Мэргэжлийн коллеж, их дээд сургуулийн оюутнуудыг мод үржүүлгийн газарт дадлагажуулж ажиллуулах
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах, гэрээ байгуулах

4.4. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро-ойн аж ахуйг хөгжүүлэх – Хүнс, хөдөө аж ахуйн газар

- Хэрлэн, Мөрөн сумдад говь, хээрийн бүсийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ бүхий агро ойн аж ахуй байгуулах
- Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян -Улаан тосгонд говь хээрийн бүсийн эмийн ургамал бүхий агро ойн аж ахуй байгуулах
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын тариан талбайг тойруулж ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах

4.5. Иргэдийн дунд бүх нийтийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх, мод тарих сургалт сурталчилгааны ажлыг бүх түвшинд зохион байгуулах – Боловсрол шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсрол төв

- Мод тарих, арчилж ургуулах талаар аргачлал, заавар зөвлөмж, гарын авлага, цахим хичээл зэргийг боловсруулж бүх нийтийн мод тарих, ургуулах боловсролыг нэмэгдүүлэх
- Бүх шатны сургалтын байгууллагын сурагч нарт мод тарих, ургуулах боловсрол олгох
- Жил бүр багш ажилчдын дунд зорилтот компанит аян зохион байгуулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллах

4.6. Мэргэжилтэй ажилтан, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх – Политехникийн коллеж

- Ойжуулалт, ойн аж ахуй, агро аж ахуй, мод үржүүлэх, бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх (2.5 жилийн сургалттай)
- Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн арчилгааны мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх (1 жилийн сургалттай)
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран богино хугацааны мэргэшүүлэх түр сургалтанд иргэдийг хамруулах

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

Хэнтий аймгийн хэмжээнд 2030 он хүртэл 30 сая модыг тарьж, ургуулсан байх ба үүний хүрээнд:

5.1. Төв, суурин газрын ногоон байгууламжийн зураглал болон суурь судалгаатай болж мэдээллийн санг бүрдүүлж, мод тарих, арчлах, ургуулахад шаардлагатай усны нөөцийг бүрдүүлж, саарал ус, гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлсэн байна.

5.2. Жил бүр бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг 4000 га-аар нэмэгдүүлж 10.0 сая ширхэг мод тарьж, ургуулсан байна. “Өрх бүр ногоон төгөл” аянд 10000 өрхийг хамруулсан байна.

5.3. 15800 га талбайд ойжуулалт хийж, 3000 га талбайд ойн зурвас байгуулж, 2000 га талбайд ойн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулж, 22.0 сая ширхэг мод тарьж, ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна. Шилмүүст болон навчит модны 2000 кг үрийн нөөцийг бүрдүүлж, 4 сумын мод үржүүлгийн газрыг өргөжүүлж, 3 суманд шинээр мод үржүүлгийн газар байгуулж шаардлагатай тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлсэн байна.

5.4. 4 суманд хүнсний ногоо, жимс жимсгэнэ, эмийн ургамал, тариалангийн талбайн агро-ойн аж ахуйг хөгжүүлж, 10000 га тариан талбайг тойруулж ойн зурвас байгуулсан байна.

5.5. Иргэд олон нийтэд сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, бүх шатны сургалтын байгууллагаар дамжуулан бүх нийтийн экологийн боловсролыг нэмэгдүүлж, 100-аас дээш сургагч багш нарыг бэлтгэсэн байна.

5.6. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн арчилгаа болон ойжуулалт, ойн аж ахуй, агро аж ахуй, мод үржүүлэх, бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр 200-аас дээш мэргэжилтэй ажилтан, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэсэн байна.

ЗУРГАА. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


6.1. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлаг байгууллагууд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ тус бүрийг тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр жил бүр үнэлнэ.

6.3. Ажлын явц, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 03 -ны өдрийн аравдугаар хуралдааны 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар байгуулагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулахад хяналт тавих ажлын хэсэг хариуцна.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар жил бүр хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулж ажиллана.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт



“ГУЧИН САЯ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2022-2030 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	Хариуцах байгууллага	Хамтран зохион байгуулах байгууллага
Зорилт 1. Мод тарих арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын зураглал гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх															
1	Сум, тосгодын төвийн ногоон байгууламжийн байрлалын зураглал гаргаж мэдээллийн сан бий болгож сумдад хүлээлгэж өгөх	Аймгийн хэмжээнд	-	18 сум, 5 тосгонд	+	+	+	+	+	+	+	+	+	ГХБХБГ	БОАЖГ, СЗДТГ
2	Шинээр таригдах модны газрыг ойжуулалт, ногоон байгууламж тус бүрээр гаргаж сум бүрт зураглал хийж сумдад хүлээлгэж өгөх	Аймгийн хэмжээнд	-	18 сум, 5 тосгонд	+	+	+	+	+	+	+	+	+		
3	Газрын доройтол, цөлжилтөд өртсөн газрын судалгаа гаргаж, мод тарих ажилд ашиглах	Аймгийн хэмжээнд	-	18 сум, 5 тосгонд	+									ГХБХБГ	ХХААГ, УЦУОШТ, СЗДТГ
4	Шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсөлд ногоон байгууламжийн тохижилтийн хэсгийг тусгах, гүйцэтгэлд хяналт тавьж хүлээж авах	Төсөл арга хэмжээний тоо, гүйцэтгэлээр	-	Шинээр баригдах бүх барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан байна.	+	+	+	+	+	+	+	+	+	ГХБХБГ	ХОХБТХ
5	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын саналыг авч тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод үржүүлгийн газрыг төлөвлөж оруулах, хууль тогтоомжинд нийцүүлэн олгох асуудлыг судлах, шийдвэрлэх	Гүйцэтгэлээр	-	Ирүүлсэн хүсэлтүүдийг шийдвэрлэнэ.	+	+	+	+	+	+	+	+	+	ГХБХБГ	СЗДТГ

14	Орон нутгийн өмчид бүртгэлтэй усны машин, ус хадгалах сав (ёмкость) зэргийг сумын болон сум дундын ойн ангиуд, мод үржүүлгийн газруудад хуваарилах ажлыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд	-	Өмчийн судалгаа гаргаж, хуваарилсан байна.	+	+												СЗДТГ	СТСХ, ОНӨГ	
Зорилт 3. Ойт хээрийн болон хээрийн бүсийн доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, ойн зурвас байгуулах, мод үржүүлэг, тарьц суулгацыг нэмэгдүүлэх																				
15	Аймгийн хэмжээний мод, модлог ургамлын суурь судалгааг бүс нутаг тус бүрээр гаргах, ойн доройтолд орсон болон хортон шавьжид өртсөн талбай, нөхөн сэргээх шаардлагатай газрын суурь судалгааг гаргах /Хэрлэн голын татмын бургасан ойг хамруулна/		Суурь судалгаатай болсон байна.	Аймгийн хэмжээнд	+		+			+				+				+	БОАЖГ	СГЗ, СДОА, СОА
16	Ойт хээрийн бүсийн сумдад ойжуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	Амьдралт 75% -аас дээш байна.	136 га	15200 га-д ойжуулалт хийнэ.			140 га	480 га	1840 га	2350 га	2860 га	3200 га	3200 га	1130 га					БОАЖГ	СДОА, СОА
			204100 тарьц	22800000 ш мод тарина.		210000 ш	720000 ш	2760000 ш	3525000 ш	4290000 ш	4800000 ш	4800000 ш	1695000 ш							
17	Хээрийн бүсийн сумдад хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	Амьдралт 75% -аас дээш байна.		3000 га-д ойн зурвас байгуулна.	33 га	53 га	160 га	347 га	453 га	487 га	667 га	667 га	133 га						БОАЖГ	СЗДТГ
				4500000 ш мод тарьна.	50000 ш	80000 ш	240000 ш	520000 ш	680000 ш	730000 ш	1000000 ш	1000000 ш	200000 ш							
18	Хэрлэн голын татмын бургасан ойн доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, бургасжуулах /Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх, Мөрөн, Баянхутаг, Мөрөн, Хэрлэн, Баян-Овоо сумд/	Сумын тоо		9 сум 90 га		10	10	10	10	10	10	10	10						БОАЖГ	ХГСГЗ
19	Ойн мэргэжлийн нөхөн байгууллагуудын	Амьдралт 75% -аас	136	1800 га	200	200	200	200	200	200	200	200	200						БОАЖГ	СЗДТГ, СДОА, СОА

	сэргээлтийн ойжуулалт хийлгэх арга хэмжээг зохион байгуулна.	дээш байна.	204100	2700000ш мод тарина.	300000 ш	300000 ш	300000 ш	300000 ш	300000 ш						
20	Иргэд, нөхөрлөл, ой мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийж, улсын ойн санд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах, уг ажлыг сурталчилах	Ойжуулалт хийсэн талбайн хэмжээгээр /га/	-	1000 га 1500000 ш тарьц	20 30000 ш	20 30000 ш	50 75000 ш	50 75000 ш	100 150000 ш	200 300000 ш	200 300000 ш	200 300000 ш	160 240000 ш	БОАЖГ	Иргэд, нөхөрлөл, ой мэргэжлийн байгууллага
21	Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Цэнхэрмандал сумдад мод үржүүлгийн газруудыг 30 га талбайгаар өргөтгөж ойжуулалтын ажилд шаардлагатай тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх	Нэмэгдүүлсэн талбайн хэмжээгээр /га/	18,5 га	Шинээр 41.4 га /өссөн дүнгээр 60 га/	11.4	15	5							БОАЖГ	СЗДТГ СДОА, СОА
22	Дадал, Хэрлэн, Баян-Овоо суманд шинээр мод үржүүлгийн газар байгуулж тарьц суулгацын нөөц бүрдүүлж, ногоон байгууламжийн тарилтанд гаргах	Шинээр байгуулсан ТҮГ-ын тоо, га талбайн хэмжээгээр	-	Дадал суманд 2 га, Хэрлэн суманд 20 га, Баян-Овоо суманд 3 га	2 га	3 га	20 га							БОАЖГ	ОББЦГХЗ, СЗДТГ
23	Үрийн нөөц бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх	Түүсэн үрийн хэмжээгээр /кг/	Шилмүүст 80 кг Навчит 7 кг	1450 кг 550 кг	70 30	150 100	200 100	300 100	350 100	350 100	30 20			БОАЖГ	СДОА, СОА
24	Ой бүхий Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин сумдын байгалийн ойгоос мод шилжүүлэн суулгуулахгүй байхад хяналт тавих	Хяналт шалгалт хийсэн тоогоор	Жилд 2 удаа хяналт хийсэн	Ой бүхий 9 суманд жил бүр 2 удаа нийт 18 удаагийн хяналт шалгалт хийнэ.	+	+	+	+	+	+	+	+	+	БОАЖГ	МХГ
25	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Мэдээллийн цар хүрээ, хүртээмж /хүний тоо/	-	Улс, аймгийн хэмжээнд жил бүр 100,0 мянгаас доошгүй хүнд мэдээлэл хүргэнэ.	100000	100000	100000	100000	100000	100000	100000	100000	100000	БОАЖГ	АЗДТГ, СЗДТГ, ГХБХБГ, БГ, НТБТ, ХХҮГ, ПК



2023 оны 10 сарын 17
 10:00

26	Мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтныг орон тоогоор ажиллуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	1 орон тоо	-	Улс, аймаг, сумын хэмжээнд үндэсний хөдөлгөөнийг сурталчилж ажиллана.	+	+	+	+	+	+	+	+	+	+	БОАЖГ	АЗДТГ
27	Мод тарих, арчлах, ургуулах чиглэлээр сургагч багш бэлтгэх	Хамрагдсан иргэдийн тоогоор	-	18 сумын хэмжээнд 100-аас доошгүй сургагч багш бэлтгэгдсэн байна.	50	50									БОАЖГ	СЗДТГ, БГ
28	Мэргэжлийн коллеж, их дээд сургуулийн оюутнуудыг МҮГ-т дадпагажуулж ажиллуулах	Хамрагдсан оюутны тоогоор	-	Жилд 20еос доошгүй оюутан ажиллуулсан байна.	+	+	+	+	+	+	+	+	+	+	БОАЖГ	СДОА, СОА
29	Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэх, туршлага судлах, гэрээ байгуулах	Шилмэл сортын шинэ үрийн нөөц бүрдүүлсэн байх	-	Үр дүнтэй хамтран ажилласан байна.	+	+									БОАЖГ	СДОА, СОА

Зорилт 4. Агро ойн аж ахуйг хөгжүүлэх

30	Мөрөн, Хэрлэн суманд говь, хээрийн бүсийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ бүхий агро ойн аж ахуй байгуулах	Хэрлэн сумын баруун хэсгийн ногооны талбайг 100% хамруулсан байна.	2.58 га	10000 ш мод тарисан байна.			5000	5000							ХХААГ	Азийн хөгжлийн банк, СЗДТГ
		Мөрөн сумын баруун хэсгийн ногооны талбайг 100% хамруулсан байна.	0.02 га	15000 ш мод тарисан байна.		5000	5000	5000							ХХААГ	СЗДТГ, ААН
31	Хэрлэнбаян улаан тосгонд говь хээрийн бүсийн эмийн ургамал бүхий агро ойн аж ахуй байгуулах			41000 ш мод тарисан байна.	3000	3000	5000	5000	5000	5000	5000	5000	5000	5000	ХХААГ	СЗДТГ, Тариалангийн ААН
32	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын тариан талбайг тойруулж ойн зурвас байгуулах	Нэмэгдүүлсэн га-гаар	10000 га	10000 га	1000	1000	1000	2000	1000	1000	1000	1000	1000	1000	ХХААГ	Тариалангийн ААН, СЗДТГ
				300000 ш мод тарисан байна.	30000	30000	30000	60000	30000	30000	30000	30000	30000	ХХААГ, СЗДТГ, Тариалангийн ААН		

Зорилт 5. Экологийн боловсролыг нэмэгдүүлэх, мод тарих сургалт сурталчилгааны ажлыг бүх түвшинд зохион байгуулах

33	Мод тарих, арчилж ургуулах талаар аргачлал, заавар зөвлөмж, гарын авлага, цахим хичээл зэргийг боловсруулж бүх нийтийн мод тарих, ургуулах боловсролыг нэмэгдүүлэх	Бэлтгэсэн цахим хичээл болон, шарын авлагын тоогоор	-	18 сум, 4 тосгоны хэмжээнд шилдэг 3-аас доошгүй цахим хичээл болон гарын авлага бэлтгэгдсэн байна.	54	54	54	54	54	54	54	54	54	БШУГ	НТБТ, СЗДТГ
34	Бүх шатны сургалтын байгууллагын сурагч нарт мод тарих, ургуулах боловсрол олгох	Бэлтгэгдсэн багшийн тоогоор	-	18 сумын 25 сургуулийн ахлах ангийн АУБ нарт сургалт хийсэн байна.	132	375	307	132	375	307	132	375	307	БШУГ	НТБТ
35	Жил бүр зорилтот компани аян зохион байгуулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллах	Ургасан модны тоогоор	40000	25 сургуулийн багш ажилчид хамтран мод тарьсан байна.	1400	3600	5000	5000	5000	5000	5000	5000	5000	БШУГ	ЕБС, Цэцэрлэгүүд
Зорилт 6. Мэргэжилтэй ажилтан, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх															
36	Ойжуулалт, ойн аж ахуй, агро аж ахуй, мод үржүүлэх, бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх (2.5 жилийн сургалттай)	Мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн тоогоор	-	50-60 хүн /анги бүрдэлт 15-20 хүн/			1 жилийн мэргэжлийн анги	3 жилийн мэргэжлийн анги			1 жилийн мэргэжлийн анги	3 жилийн мэргэжлийн анги		Политехникийн коллеж	ХХУГ, БОАЖГ, СЗДТГ
37	Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн арчилгааны мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх (1 жилийн сургалттай)	Мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн тоогоор	-	50-60 хүн /анги бүрдэлт 15-20 хүн/		1 жилийн мэргэжлийн анги	3 жилийн мэргэжлийн анги			1 жилийн мэргэжлийн анги	3 жилийн мэргэжлийн анги		Политехникийн коллеж	ХХУГ, БОАЖГ, СЗДТГ	
38	Богино хугацааны мэргэшүүлэх түр сургалтанд хамруулах	Хамрагдсан иргэдийн тоогоор	-	100 хүн /анги бүрдэлт 15-20 хүн/	Түр сургалт	Түр сургалт	Түр сургалт	Түр сургалт	Түр сургалт			Түр сургалт	Түр сургалт	Политехникийн коллеж	ХХУГ, БОАЖГ, СЗДТГ